



МОНГОЛБАНКНЫ 2017 ОНЫ III УЛИРЛЫН ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Сэдэв: “Боловсрол гэж юу вэ? Боловсрол таны амьдралд болон улс орны хөгжилд хэр чухал вэ?”

Нэг. Зорилго

Олон нийтийн дунд улирал тутам зохион байгуулж буй эссе бичлэгийн уралдаан нь иргэдийн эдийн засаг, санхүүтэй холбоотой сэдвүүдийг сонирхох сонирхлыг нэмэгдүүлэх, энэ талаарх мэдлэгээ сайжруулах хөшүүргийг бий болгох, Төв банкны зүгээс олон нийтийн эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Хоёр: Сэдвийн талаарх үндсэн мэдээлэл

Дэлхийн 200 гаруй улс хоорондоо хөгжлийн түвшин, ард иргэдийн амьдралын чанарын хувьд их, бага хэмжээгээр зөрүүтэй байдаг. Өндөр хөгжсөн, иргэдийн амьжиргаа нь хангалуун болсон улс орнууд байхад тийм биш ядуу буурай улс орнууд ч бий. Тэгвэл энэхүү ялгааг бий болгодог нэг чухал хүчин зүйл бол боловсрол гэж үзэх нь түгээмэл. Тухайлбал, хөгжлийн түвшнийг илэрхийлэх гол хэмжүүрүүдийн нэг болох Хүний хөгжлийн индекс (HDI)-ийн чухал бүрэлдэхүүн нь “мэдлэг боловсрол” юм. Түүнчлэн дэлхийд чансаагаараа дээгүүрт ордог их сургуулиудтай улс орнуудын эдийн засаг нь хүчирхэг, амьдралын түвшин нь өндөр байдаг зүй тогтол ч ажиглагддаг. Боловсрол ба эдийн засгийн сайн сайхан байдлын хоорондох хамаарлыг хувь хүн дээр ч ажиглаж болно. Мэдлэг боловсролтой хүмүүс илүү ур чадвар шаардагдах, тэр хэмжээгээр өндөр цалин орлого олох боломжтой ажил хийх нь түгээмэл зүйл. Гэхдээ мэдлэг боловсролын талаар маш олон тодорхойлолт байх бөгөөд, боловсрол гэж юу вэ гэдгийг хүн бүр харилцан адилгүйгээр ойлгох тохиолдол бий. Иймд, “Боловсролыг Та юу гэж тодорхойлох вэ?”, “Таны ажил мэргэжил, хувийн амьдралд боловсрол хэр чухал вэ?”, цаашлаад “Таны бодлоор улс орны ирээдүй, хөгжилд боловсрол хэр чухал вэ?” зэрэг асуултуудад хариулсан эссе бичиж тус уралдаанд оролцохыг урьж байна.

Гурав. Хамрах хүрээ

Тус уралдаан нь оролцогч бүрт нээлттэй бөгөөд мэргэжил, нас, хүйс, иргэншил харгалзахгүй болно.

Дөрөв. Эссэнд тавигдах шаардлага

- ✓ 800-1000 үгэнд багтаан Монгол хэлээр бичих;
- ✓ Нүүр хуудсанд өөрийн нэр, ажил, мэргэжил, холбоо барих 2 утас, и-мэйл хаягийг бичих;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах);

- ✓ Бичгийн стандарт:
- Үсгийн фонт: Times New Roman;
- Үсгийн хэмжээ: 12;
- Мөр хоорондын зай: 1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм.

Тав.Шалгуур үзүүлэлтүүд

	Оноо
1. Ерөнхий шаардлага	
<i>Цаг баримтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/</i>	10
<i>Үгийн тоо /800-1000 үг/</i>	5
<i>Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../</i>	5
2. Эссений сэдэвтэй нийцсэн эсэх	
<i>Боловсрол гэж юу вэ- тодорхойлсон байдал</i>	10
<i>Боловсрол хэр чухал талаарх үзэл бодлоо илэрхийлсэн байдал</i>	10
3. Эссений чанар	
<i>Үг үсгийн алдаа</i>	5
<i>Найруулга зүй</i>	5
<i>Логик дэс дараалал</i>	10
<i>Судалгаа/Тоо баримт ашигласан байдал</i>	10
<i>Энгийн ойлгомжтой байдал</i>	10
<i>Уншихад сонирхолтой байдал</i>	10
<i>Шинэ санаа /давтагдаагүй/</i>	10
Нийт	100

Зургаа.Шалгаруулалт

Тэмцээний дүнг 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зарлах бөгөөд шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.

Шагнал:

- I байр: 300,000 төгрөг + Өргөмжөл
- II байр: 200,000 төгрөг + Өргөмжөл
- III байр: 100,000 төгрөг + Өргөмжөл

Долоо. Материал хүлээн авах хугацаа:

Материалыг 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 17 цаг хүртэл essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна. Дэлгэрэнгүй мэдээллийг mongolbank.mn вэб хуудаснаас болон 310119 дугаарын утсаар лавлана уу.

МОНГОЛБАНК

ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

2017 он